



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/256

Улаанбаатар хот

Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,899,900.00 (дөрвөн сая найман зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар (Б.Мэндсайхан)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 4,899,900.00 (дөрвөн сая найман зуун ерэн есөн мянга есөн зуун) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар Нийслэлийн Өмчийн харилцааны газарт акт үйлдэн хүлээлгэн өгч, Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар (Б.Мэндсайхан)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500380



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ҮХХХК-н шийдвэр
1	Apple IPAD Таблет 64GB	2	ш	1	4,899,900.0	4,899,900.0	3,538,816.6	1,361,083.4	-	-	-	-	-
	Тоног төхөөрөмжийн дүн				4,899,900.0	4,899,900.0	3,538,816.6	1,361,083.4	-	-	-	-	-
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					4,899,900.0	3,538,816.6	1,361,083.4					
	Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгийн дүн												
	Устгах хөрөнгө												
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн					4,899,900.0	3,538,816.6	1,361,083.4					
	Худалдан борлуулах дүн						-						
	Худалдсанаас олох орлого						-						
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/						-						